



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 06 сарын 09 өдөр

Дугаар 8/24

Мөрөн сум

**Засаг даргын Тамгын газрын Өмч хамгаалах
байнгын зөвлөлийг байгуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, дахь хэсэг, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор баталсан Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журмын 2.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус ажлын хэсэг нь Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журмыг мөрдлөг болгон Сумын Засаг даргын Тамгын газрын эд хөрөнгийн бүртгэл, хувийн хэрэг хөтлөх, улсын бүртгэлд бүртгүүлэх, хөрөнгийн тооллого хийх, санхүүгийн болон статистикийн мэдээ, тайланг гаргах, холбогдох журмын дагуу тайлагнах ажлыг хариуцсугай.

2.Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга:	Ц.Болорцэцэг	Санхүү албаны дарга бөгөөд төсвийн ерөнхий нягтлан бодогч
Нарийн бичгийн дарга :	Г.Дашмаа	Төрийн сангийн мэргэжилтэн
Гишүүд:	А.Алимаа	Нийгмийн бодлогын мэргэжилтэн
	Г.Хишигбаатар	Хууль эрх зүйн мэргэжилтэн
	Ш.Баасандорж	Байгаль орчны улсын байцаагч

3.Өмч хамгаалах зөвлөлийн төлөвлөгөө гарган батлуулж ажиллахыг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Төрийн сангийн мэргэжилтэн (Г.Дашмаа)-д удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Зөвлөлийн дарга Санхүү албаны дарга бөгөөд төсвийн ерөнхий нягтлан бодогч (Ц.Болорцэцэг)-т тус тус даалгасугай.

ДАРГА

Н.НАМЖИЛНОРОВ